



Цөлийн бүсэд ховор, ховордсон мод, сөөг үржүүлэх арга барил Говь-Алтай аймаг, Баянтоорой тосгон, Тэгшийн булаг

Монгол Улсын “Улаан ном”-нд бүртгэгдсэн ургамлын 30 орчим хувь нь говь цөлийн бүсэд ургадаг бөгөөд тэдгээрээс нэн ховор, устаж болзошгүй ургамлын ихэнх нь цөлийн бүсийн баянбүрдийг түшиглэн цөөн тоогоор үлдэж хоцорчээ. Говь цөлийн бүсийн ургамлан нөмрөгийн тэн хагасыг эзэлдэг мод, сөөгний ургах орчин доройтож заг, тоорой, хайлаас, жигд, сухай, харгана, хармаг, азар, гандигар зэргийн гол ач холбогдол бүхий ургамлууд ховордон байгальд тархан ургах хүрээ хумигдаж байна [Хауленбек., 2005]. Тэдгээрийг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимтэй явуулах нь чухал байна. Хуурай гандуу бүс нутагт ургах чадвартай мод, сөөгийг зориудын аргаар тарималжуулан, тэдгээрийг ойжуулалтын бүхий л хэлбэрийн үйл ажиллагаанд ашиглах хэрэгцээ, шаардлага нэн их байдаг. Говийн Их Дархан Цаазат Газрын (ГИДЦГ) Хамгаалалтын захиргаа 1988 онд Тэгшийн булгийн усыг түшиглэн Мод Үржүүлгийн Газар байгуулж, цөлийн бүсэд анх удаа говийн модлог ургамлыг үржүүлэх судалгааны ажлын үндсийг тавьсан байна. Өнөөдрийн байдлаар тус мод үржүүлгийн газарт Сибирь улиас (*Populus sibirica*), Мөнгөлөг улиас (*Populus alba*), Элдэвнавчит улиас (*Populus diversifolia*), Татар агч (*Acer tataricum*), Тарваган хайлаас (*Ulmus pumila*), Тэмээн харгана (*Cargana spinosa*), Сибирь хармаг (*Nitraria sibirica*), Бариулт бүйлс (*Amygdalus pedunculata*), Муркрофтын жигд (*Elaeagnus moorcroftii*), Шар хуайс (*Caragana arborescens*), Сийрэг нохойн хошуу (*Rosa laxa*), Яшилдуу чацаргана (*Hippophae rhamnoides*), Цагаан бургас (*Salix ledebouriana*), Олон цэцэгт сухай (*Tamarix ramosissima*) зэрэг мод, сөөгийг тарьж үржүүлж байна.

Зүүн зургийн тайлбар: Үрээр ургуулсан Сийрэгнойн хошуу (*Rosa Laxa*), Сибир хармаг (*Nitraria sibirica*)-ийн төрх байдал
Баруун зургийн тайлбар: Мод үржүүлгийн газар



Байршил: Говь-Алтай аймаг, Баянтоорой тосгон, Тэгшийн булаг
Газар ашиглалтын төрөл: Мод үржүүлэг, туршилт судалгаа
Уур амьсгал: Хуурай
MONCAT мэдээллийн сангийн нэр зүй: QT MON - 14
Холбогдох технологи: QT MON - 6
Мэдээллийг цуглуулсан хүн/байгууллага: А.Хауленбек, Б.Мижиддорж, Л.Мөнхнасан, Ц.Ганчөдөр - Геоэкологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны төв.
Он, сар, өдөр: 2009.10.20
Арга барилыг нэвтрүүлсэн хувь хүн, байгууллага: ГИДЦГ-ын хамгаалалтын захиргаа
Холбогдох утас: 99949606, 0148226526

1. Цөлжилт, уур амьсгалын дулаарал
2. Говийн бүсийн ургамлан бүрхэвчийн доройтол
3. Ховор, ховордсон модлог ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх
4. Ган/хуурайшилд тэсвэртэй мод сөөгийг бэлтгэн нийлүүлэх
5. Говийн баянбүрд, булаг, шандыг хамгаалах

Зорилго

Ховор, ховордсон модлог ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, тарималжуулах замаар хуурай гандуу бүсэд ойжуулалтын бүхий л хэлбэрт (ойн зурвас, төгөл ой, баянбүрдийн нөхөн сэргээлт, хот суурингийг цэцэрлэгжүүлэлт г/м) ашиглах тарьц, суулгацыг бэлтгэх.

Шийдвэрлэхэд чиглэгдсэн асуудал

Үндсэн	Товч тодорхойлолт	Шийдвэрлэх арга зам
Ховор, ховордсон модлог ургамлыг тарьмалжуулах	Модлог ургамлыг тарьж ургуулах боломжийг тодорхойлох	Тухай бүр үр, мөчир бэлтгэн агротехникийн дагуу тарьж ургуулах
Тарьц, суулгац бэлтгэн ойжуулалт нөхөн сэргээлтэнд ашиглах	Стандарт шаардлага хангасан тарьц, суулгац бэлтгэх	Ойн зурвас, төгөл ой байгуулах замаар элсний нүүлтийг сааруулах, хөрс бэхжүүлэх, төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх. Нөхөн сэргээлтэнд ашиглах.
Арга барил нь өрөө өөрийгөө санхүүжүүлдэг байх	Хуурай гандуу бүс нутагт ургах чадвартай тарьц, суулгацын хэрэгцээ шаардлага их байдаг.	Тарьц, суулгацыг зарж борлуулах замаар өөрөө өөрийгөө санхүүжүүлэн мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг хөгжүүлэх боломжтой

Оролцоо, шийдвэр гаргах

Нийгмийн бүлэг



Ажилчингазар ашиглагчид




Инженер, судлаачид

Арга барилд шаардагдах зардал

БОАЖЯ	50%
ГИДЦГ	50%
Нийт	100%

Технологи сонголтод шийдвэр гаргагчид: БОАЖЯ, ШУ-ны байгууллагууд **Оролцооны зарчмын бүрдүүлэгч:**, Говийн Их Дархан Цаазат Газрын хамгаалалтын захиргаа, төсөл хөтөлбөрүүд



Зохион байгуулалтын бүдүүвч

1. *Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам*: Ойжуулалтын чиг хандлагыг тогтоож бодлогын хүрээнд ойжуулалтын ажлын цар хүрээ, хэмжээг тусгаж өгсөн
2. *Судлаач мэргэжилтнүүд*: Судалгаа шинжилгээний үндэслэлтэйгээр модлог ургамлыг ургуулах үеийн агро-биологийн үндэслэлийг боловсруулна
3. *Говийн Их Дархан Цаазат Газар*: Нэгдсэн мод үржүүлгийн газар байгуулж, мэргэжилтэн ажиллуулан ховордсон модлог ургамлыг үржүүлэх ажлыг гүйцэтгэдэг.

Мэдлэг түгэээн дэлгэрүүлэх

Сургалт: Тодорхой бус

Түгээн дэлгэрүүлэлт: Авирмэд А. Монголын их говьд ургадаг Тоорой (*Populus diversifolia* Schrenl)-н судалгааны зарим асуудалд //“Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм” эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ. 2004. Х. 19-24., Базарсад Ч. Хауленбек А. Авирмэд А. Монгол орны тоорой, жигд, сухай. УБ. 2003. 50 х., Базарсад Ч. Хауленбек А. Заг, жигд, хайлаас, тоорой зэрэг нутгийн мод, сөөгийг тарималжуулах технологи. ЭША-ын тайлан. УБ. 1989-1993. Эх бичмэлээр Ой хайгуул төслийн архивт бий., Базарсад Ч. Хауленбек А. Чулуун Ч. Цөлийн нөхцөлд тоорой, жигд, сухай, загийн тарьц, суулгац ургуулах боломж. //ОАЭШЗТ-ийн хүрээлэнгийн бүтээл. 11. УБ. 1990. Х. 10-23., зэрэг бүтээлүүд хэвлэгдэн олны хүртээл болжээ.

Судалгаа: Биологийн ухааны дэд доктор Ч.Базарсад, эрдэм шинжилгээний ажилтан А.Хауленбек нар (1987-1997), А.Авирмэд (1992-2002) нар цөлийн бүсэд нутгийн мод, сөөгийг тарималжуулах агротехнологийг боловсруулах судалгааны ажлыг гүйцэтгэн үр, мөчрийн болон үндэсний тайрдсаар ургуулах ажиглалт, судалгааны ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн дэмжлэг: Орон нутгийн удирдлагын зүгээс дэмжиж ажилладаг.

Урамшуулал

Ажиллах хүч: ГИДЦГ-ын хамгаалалтын захиргааны мод үржүүлгийн газрын мэргэжилтэн, ажилчид ховор, ховордсон мод сөөгийг үржүүлэх ажилд биечлэн оролцдог.

Хөрөнгө оруулалт: БОАЖ-ын яам, “Их говийн шүхэр зүйлийг хамгаалах төсөл”, ГИДЦГ-ын хамгаалалтын захиргаа.

Зээл олголт: Зээл олгогдоогүй

Орон нутгийн байгууллагуудад үзүүлэх дэмжлэг: Орчны бүс нутгийн сум, багийн удирдлага, байгууллага, иргэдийн хэрэгцээнд мод, сөөгний суулгацыг тарьж өгөх замаар дэмжлэг үзүүлдэг.

Урамшуулал олгохын урт хугацааны нөлөө: Эерэг нөлөөтэй

Мониторингийн объект	Индикатор	Газар ашиглагчдын санаачлага
Био-физик	Ховор, ховордсон мод, сөөг ургамал	Тэдгээрийг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулалтын бүхий л үйл ажиллагаанд ашиглах
Техник	Тарьж ургуулах	Ганд тэсвэртэй мод, сөөгний тарьц суулгац бэлтгэх
Эдийн засгийн үр ашиг Хамрах талбай	Суулгацыг нөхөн сэргээлт, цэцэрлэгжүүлэлтэнд нийлүүлэх	

Арга барилын үзүүлэх үр нөлөө

Мониторинг, үнэлгээ хийсний үндсэн дээр гарсан өөрчлөлтүүд: Мониторинг, үнэлгээ хийгдэж байгаа, ач холбогдол сайтай

Хөрс, усны менежмент сайжрах: Ганд тэсвэртэй тарьц суулгац бэлтгэн хөрсний эвдрэл, ус хамгаалах зорилгоор нөхөн сэргээлтэнд ашиглаж цөлжилт явагдах сөрөг үр дагаврыг бууруулна.

Бусад төсөл, газар ашиглагч нар арга барилд суралцаж эзэмшсэн эсэх: Тус арга барил технологийг орчны бүс нутгийн байгаль орчны мэргэжилтнүүд газар дээр нь танилцан орон нутагтай тарьц суулгацыг таималжуулах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Тухайлбал: Орчны бүсийн сумын төвүүдийг цэцэрлэгжүүлэх, ойжуулах арга хэмжээнд зориулан 30 000 гаруй тарьц, суулгац бэлтгэж нийлүүлсэн байна.

Тогтвортой байдал: Уг арга барилыг хэрэгжүүлснээр ховор ховордсон модлог ургамлыг устах аюулаас хамгаалж, нөхөн сэргээх боломжийг тодорхойлно.

Дүгнэлт

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах

→ Модлог ургамлыг тухайн экологийн орчин нөхцөлд нь үржүүлэх нөхцөл бүрдсэн

→ Булгийн урсгал усыг түшиглэн, газрыг үнэгүй ашигладаг

→ Мод үржүүлгийн газрын ойн зурвас хамгаалах хэмжээний өндөр, шигүүрлийг үүсгэсэн учир нөмөр нөөлөгтэй байдаг.

→ Эх ургамлын талбайд зарим төрлийн мод, сөөгний үр, мөчир бэлтгэх боломжтой болсон.

Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах

→ Байгаль цаг уурын эрс тэс орчин нөхцөлд мод, сөөгийг үржүүлэх ажил эрсдэл өндөртэй байдаг.

→ Урсгал усаар мод, сөөгийг услах нь хөрсөнд агуулагдах эрдэс бодисыг уусгаж ургамалд жигд түгээж өгдөг.

→ Ойн зурвас, эх ургамлын талбайн нөмөр нөөлөгт мод, сөөгийг үр, мөчрөөр үржүүлэхэд амьдралт болон өсөлтөнд эерэг нөлөөтэй байдаг.

→ Цаашид үржүүлгийн газрын эх ургамлын талбайг өргөжүүлэн төрөл зүйлийг нь баяжуулах тал дээр анхаарч ажиллаж байна.

Холбоо барих байгууллага: ШУА-ийн Газараүй - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар
Утас: 976-11-325487 **Факс:** 976-11-322187
Вэбсайт: www.igq.ac.mn, www.geo-eco.mn